



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/ааа

Булган сум

“Аймгийн оны шилдгүүд шалгаруулах
журам”-ыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Аймгийн оны шилдгүүд шалгаруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын дагуу шагналд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/605 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
12 дугаар сарын 17-ны ний өдрийн
А.А.А дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ОНЫ ШИЛДГҮҮД ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Зорилго: Булган аймгийн хөгжил, дэвшилд хөдөө, аж ахуй, дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлалын чиглэлээр бодит хөрөнгө оруулалт хийж, үнэт хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжий үйл ажиллагааг алдаршуулах, эрхэлсэн салбарын хүрээнд өөрийн мэдлэг боловсрол, хичээл зүтгэл, хүч чадлаа дайчлан ажиллаж, онцгой амжилт гаргасан төрийн болон хувийн хэвшлийн ажилтан, албан хаагчдыг шалгаруулан урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

Оны шилдгээр шалгаруулах салбар:

1. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын аймгийн шилдэг түшээ (Аймаг, сум багийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, хурлын ажилтан)
2. Төрийн захиргааны салбарын оны шилдэг ажилтан
3. Хууль, хяналтын салбарын оны шилдэг ажилтан
4. Санхүүгийн салбарын оны шилдэг ажилтан
5. Боловсролын салбарын оны шилдэг ажилтан
6. Эрүүл мэндийн салбарын оны шилдэг ажилтан
7. Соёл, спортын салбарын оны шилдэг ажилтан
8. Нийгмийн хамгаалал, иргэний нийгмийн байгууллагын салбарын оны шилдэг ажилтан
9. Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын оны шилдэг ажилтан
10. Дэд бүтцийн салбарын оны шилдэг ажилтан
11. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын оны шилдэг ажилтан
12. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын оны шилдэг ажилтан
13. Шилдэг хөрөнгө оруулагч (Нийгмийн салбар)
14. Шилдэг хөрөнгө оруулагч (Хөдөө, аж ахуйн салбар)
15. Шилдэг хөрөнгө оруулагч (Дэд бүтцийн салбар)
16. Шилдэг хөрөнгө оруулагч (Үйлдвэр үйлчилгээний салбар)
17. Шилдэг хөрөнгө оруулагч (Аялал жуулчлалын салбар)

Шалгаруулах журам:

1. Аймгийн оны шилдэг ажилтанд нэр дэвшигчийн материалыг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Аймгийн Засаг даргын тамгын газрын холбогдох хэлтэст ирүүлнэ.
2. Аймгийн тухайн салбарын шилдэг хөрөнгө оруулагчийн материалыг холбогдох байгууллагууд жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор хүлээн авч холбогдох хэлтэст уламжилж, шалгаруулалтыг зохион байгуулна.
3. Журмын дагуу шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгж албан хаагчдын материалуудыг тухайн нэр дэвшүүлсэн эрх бүхий албан хаагч 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Аймгийн Засаг даргын дэргэдэх удирдлагын багийн хуралд

танилцуулж, аймгийн Засаг даргын удирдлагын багийн гишүүдийн саналаар шийдвэрлүүлнэ.

4. Аймгийн Засаг даргын удирдлагын багийн гишүүдээс оны шилдгүүдэд санал оруулж, нэр дэвшүүлэн хэлэлцүүлж болно.

Шилдэг ажилтны бүрдүүлэх материал:

- ✓ Ажил байдлын тодорхойлолт
- ✓ Анкет
- ✓ Сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтүүд
- ✓ Гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээг үнэлсэн үнэлгээ багтана.
- ✓ Тухайн онд гүйцэтгэсэн онцлох ажлын жагсаалт

Шилдэг хөрөнгө оруулагчийг хөдөө, аж ахуй, дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлалын чиглэлээр аймгийн нийгэм эдийн засгийн салбарын хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулж, бодит хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийж, ажлын байрыг нэмэгдүүлэн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэн тэлж, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлсэн байдлыг үндэслэн шалгаруулна.

Шилдэг ажилтны тодорхойлолтыг доорх хэлтсүүд бэлтгэн удирдлагын багт уламжилна.

- ✓ Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын шилдэг түшээг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба
- ✓ Төрийн захиргааны салбарын оны шилдэг ажилтныг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
- ✓ Хууль хяналтын салбарын оны шилдэг ажилтныг Хууль, эрх зүйн хэлтэс
- ✓ Санхүүгийн салбарын оны шилдэг ажилтныг Санхүү, төрийн сангийн хэлтэс
- ✓ Боловсролын салбарын оны шилдэг ажилтан, Эрүүл мэндийн салбарын оны шилдэг ажилтан, Соёл, спортын салбарын оны шилдэг ажилтан, Нийгмийн хамгаалал, иргэний нийгмийн байгууллагын салбарын оны шилдэг ажилтныг Нийгмийн бодлогын хэлтэс
- ✓ Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын оны шилдэг ажилтан, Дэд бүтцийн салбарын оны шилдэг ажилтан, Хүнс, хөдөө аж ахуйн салбарын оны шилдэг ажилтан, Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын оны шилдэг ажилтныг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсүүд тус тус тодорхойлно.

Шалгуур үзүүлэлт:

- ✓ Булган аймгийн нийгэм, эдийн засгийн салбарт үнэтэй хувь нэмэр оруулж, бодит хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийсэн байх.
- ✓ Ажлын байрыг нэмэгдүүлэн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэн тэлсэн байх
- ✓ Нийгмийн хариуцлагыг хүрээнд бодитой ажлыг зохион байгуулсан байх
- ✓ Бүтээлч санаачилгатай ажиллаж, шинэ санал санаачилга гаргасан байх

- ✓ Иргэдэд шуурхай, шударга, чанартай үйлчилгээг хүргэж, иргэдийн зүгээс гомдол гараагүй байх
- ✓ Төрийн ажил үйлчилгээг иргэдэд хүргэх, хууль сурталчлах, шинээр гарсан болон дагаж мөрдөгдөж байгаа журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байх
- ✓ Төрийн албан хаагчийн ёс зүй, нэр хүндэд харшилсан зөрчилгүй байх
- ✓ Шинэ техник, технологи, инновацыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байх
- ✓ Олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй санаачилгатай оролцдог, ажлын байрны цаг ашиглалт, ажлаа цалгардуулдаггүй байх
- ✓ Хамт олондоо нэр хүндтэй, бусдыгаа үйл хэрэг, зан харилцаагаараа үлгэрлэдэг байх
- ✓ Урлаг, спортын онцгой амжилт гаргасан байх зэрэг шалгуурыг хангасан байна

Шагналын хэмжээ:

Аймгийн шилдэг ажилтныг тус бүр 1,000,000 (нэг сая) төгрөгийн мөнгөн шагнал бүхий дурсгалын зүйлээр шагнаж урамшуулна.

Шилдэг хөрөнгө оруулагчийг цом, өргөмжлөлөөр шагнаж урамшуулж, үйл ажиллагааг алдаршуулан, иргэд, олон нийтэд сурталчлан таниулна.

--o00o--